



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/406

Эрдэнэт

### Сургалтанд оролцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.6 /а/, 29.2 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтыг ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батлан хамгаалах яамны 2017 оны Үйл ажиллагааны төлөвлөгөө, Батлан хамгаалахын сайд Орхон аймгийн Засаг даргатай 2017 онд хамтран ажиллах гэрээний дагуу 2017 оны 06 дугаар сарын 03-нд болох Дорноговь аймгийн Зүүнбаянд байрлах Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн шинэ дайчдын тангараг өргөх арга хэмжээнд оролцож, манай аймгаас татагдан хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах, Батлан хамгаалах яамнаас Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 2017 оны 07 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд зохион байгуулагдах Төвийн бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын цэргийн бэлтгэл сургалтанд Цэргийн штабын офицерууд, Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг бэлтгэлийг хангаж оролцуулах ажлуудыг зохион байгуулахыг Цэргийн штабын дарга хурандаа Г.Батсуурьт даалгасугай.

2. Төвийн бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын цэргийн бэлтгэл сургалтанд оролцох албан тушаалтангуудын нэрсийн жагсаалтыг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Дорноговь аймгийн Зүүнбаянд байрлах Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн шинэ дайчдын тангараг өргөх арга хэмжээнд оролцож, манай аймгаас татагдан хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах, Батлан хамгаалах яамнаас Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 2017 оны 07 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд зохион байгуулагдах Төвийн бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын цэргийн бэлтгэл сургалтанд шаардагдах 1901000 /Нэг сая есөн зуун нэг мянган / төгрөгийг орон нутгийн цэрэг татлага, дүйцүүлэх албаны цуглалалт, бэлтгэл сургуулилтын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc  
0200001844

Аймгийн Засаг даргын 2017 оны  
07 дугаар сарын 03 өдрийн  
406 дугаар захирамжийн хоёрдугаар  
хавсралт

**Нэг: ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗҮҮНБАЯНД БАЙРЛАХ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 336 ДУГААР  
АНГИЙН ШИНЭ ДАЙЧДЫН ТАНГАРАГ ӨРГӨХ АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОХ  
ЗАРДЛЫН ТӨСӨВ**

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээнүүд	Тоо хэмжээ, нэгж	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн шинэ дайчдын тангараг өргөх арга хэмжээнд оролцох манай аймгаас татагдан хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах, Засаг даргын мэндчилгээг гардуулахад бусад үйл ажиллагаанд шаардагдах шатахууны зардал	A-92=389 л	1650	643000
2	<b>Бүгд</b>			<b>643000</b>

**Хоёр. СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМАНД 2017 ОНЫ 07 ДУГААР САРЫН 19-22-НЫ  
ӨДРҮҮДЭД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ТӨВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА НАРЫН ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТАНД ОРОЛЦОХОД ШААРДАГДАХ  
ТӨСВИЙН ТООЦОО**

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээнүүд	Тоо хэмжээ, нэгж	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Батлан хамгаалах яамнаас Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 2017 оны 07 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд зохион байгуулагдах Төвийн бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын цэргийн бэлтгэл сургалтанд оролцох бүрэлдэхүүний байр хоолны зардал	8 хүн	80000	640000
2	Сургалтанд оролцох шатахууны зардал	A-92= 120 л	1650	198000
3	Сургалтын хэрэглэгдэхүүний зардал	7 хүн	60000	420000
4	<b>Бүгд</b>			<b>1258000</b>
5	<b>Нийт</b>			<b>1901000</b>